

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 2 - ны өдрийн 311 дүгээр тушаалын хавсралт

ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас гаргаж буй үнэт цаас /цаашид ТБҮЦ гэх/-ны арилжаатай холбогдох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1 **“ТБҮЦ”** гэж Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжаалж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээрээ эргэн төлөгдөх үнэт цаасыг;

1.2.2 **“ТБҮЦ-ны хугацаа”** гэж анх арилжаалсан өдрөөс буцаан төлөгдөх хүртэлх хугацааг;

1.2.3 **“ТБҮЦ-ны хүү”** гэж тухайн үнэт цаасыг хямдруулан худалдаж буй хямдруулалтын хувиар илэрхийлэгдэх жилийн хүүг;

1.2.4 **“ТБҮЦ-ны арилжааны мэдэгдэл”** гэж Монголбанкны Захирлуудын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ТБҮЦ-ны арилжааны нөхцлийг тусгасан баримт бичгийг;

1.2.5 **“Хямдруулсан үнэ”** гэж нэрлэсэн үнээс хямдруулалтын хувиар хямдруулан худалдан авч буй үнийг;

1.2.6 **“Нэрлэсэн үнэ”** гэж үнэт цаасны буцаан худалдан авах өдөр төлөгдөх мөнгөн дүнг;

1.2.7 **“Тогтмол хүүтэй арилжаа”** гэж Монголбанкнаас зарласан тогтмол хүүгээр банкууд зөвхөн хэдий хэмжээний үнэт цаас худалдан авах тухай саналаа ирүүлж оролцох арилжааг;

1.2.8 **“Хүүгээр өрсөлдөх арилжаа”** гэж Монголбанкнаас худалдах ТБҮЦ-ны хэмжээг зарлаж банкууд хүү болон хэмжээний саналаа ирүүлсэнээр хамгийн бага хүүний саналаас эхлэн хуваарилах арилжааг;

1.2.9 **“ТБҮЦ-ны репо санхүүжилт”** гэж банк Монголбанкнаас санхүүжилт авах зорилгоор өөрийн эзэмшилд буй үнэт цаасаа тохиролцсон үнээр тогтоосон хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэйгээр Монголбанкинд худалдах гэрээг;

1.2.10 “**Банк хоорондын цахим арилжааны систем**” гэж Монголбанк болон банкуудын хооронд хийж буй банк хоорондын захын арилжааг гүйцэтгэх цахим системийг.

1.3 ТБҮЦ нь 1 хүртэл жилийн хугацаатай, бүртгэлийн хэлбэртэй, нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна.

1.4 ТБҮЦ-нд активын эрсдлийн сан байгуулахгүй.

1.5 ТБҮЦ-ыг дараахь банкууд худалдан авах эрхтэй:

1.5.1 Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй, “Төв банкны үнэт цаасны цахим арилжааны ерөнхий гэрээ”-нд нэгдэн орсон банк,

1.5.2 Илүүдэл нөөцтэй банк ТБҮЦ-ны арилжаанд оролцох эрхтэй бөгөөд зөвхөн илүүдэл нөөцийн хэмжээгээр ТБҮЦ-ыг худалдан авч болно. Арилжаа явагдахаас өмнөх өдрийн Монголбанк дахь тухайн банкны төгрөгийн харилцах дансны үлдэгдэл ба арилжаа явагдах өдөр тухайн банкинд буцаж байгаа ТБҮЦ-ны дүнгийн нийлбэрийн дүнгээс Монголбанкнаас тухайн банкинд тогтоосон заавал байлгах нөөцийн илүү гарсан хэмжээг илүүдэл нөөц гэх бөгөөд ийм банкныг илүүдэл нөөцтэй банк гэж үзнэ.

1.6. ТБҮЦ-ыг дараахь хэлбэрээр арилжаалж болно:

1.6.1. Монголбанкнаас гаргасан үнэт цаасыг банкинд худалдан борлуулах анхдагч зах зээлийн үйл ажиллагаа;

1.6.2. Төлөгдөх хугацаа нь болоогүй эзэмшиж буй үнэт цаасыг банкууд өөр хоорондоо худалдах, худалдан авах; репо нөхцлөөр худалдах, худалдан авах; Монголбанкнаас банкуудад ТБҮЦ-ны репо санхүүжилт олгох хоёрдогч захын үйл ажиллагаа.

ХОЁР. ТБҮЦ-ны анхдагч захын арилжааг зохион байгуулах

2.1 ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй, эсвэл хүүгээр өрсөлдөх гэсэн хоёр зарчмаар явуулна. Тогтмол хүүтэй арилжаа нь хэмжээг хязгаарласан, эсвэл хязгаарлаагүй хэлбэртэй байж болно.

2.2 Долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй арилжааны зарчмаар явуулна. ТБҮЦ-ны бусад арилжаа нь хүүгээр өрсөлдөх зарчмаар явагдана.

2.3 Долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүү бол Монголбанкны бодлогын хүү байна.

2.4 ТБҮЦ-ны эргэн төлөгдөх өдөр нь нийтээр амрах өдөр таарч байвал уг өдрийн өмнөх ажлын өдөр төлөгдөхөөр арилжааг зарлана.

2.5 Арилжаа хийх, дуусах өдөр нийтээр амрах өдөр таарч, долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг 5-аас 9 хоногийн хугацаатайгаар гаргавал, уг арилжааг долоо хоногийн ТБҮЦ-тай адил зарчмаар явуулна.

2.6 Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх) нь мөнгөний бодлогын зорилт, “Макро эдийн засаг, банк, санхүүгийн системийн үзүүлэлтүүд” (1А Хавсралт)-ийн одоо болон ойрын ирээдүйн өөрчлөгдөх хандлага, “Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б Хавсралт)-ыг үндэслэн долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ны хүүгийн хувь болон хэмжээг хязгаарлахаар бол гаргах хэмжээний талаарх саналыг Монголбанкны Захирлуудын Зөвлөлд танилцуулна. Монголбанкны Захирлуудын зөвлөлөөс ТБҮЦ-ны хүүгийн хувийг тогтооно.

2.7 **Тогтмол хүүтэй бөгөөд хэмжээг хязгаарлахгүй арилжаа** нь дараахь зарчмаар явагдана:

2.7.1 ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны удирдлагын шийдвэрийг үндэслэн гаргасан арилжааны Мэдэгдлийг 2 дугаар Хавсралтын дагуу банкуудад “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр хүргэнэ.

2.7.2 МБСГ нь ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлийг арилжаа хийх өдрийн 9.30 цагт багтаан “Банк хоорондын цахим арилжааны систем”-д оруулна.

2.7.3 Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9.30-11.00 цагийн хооронд “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т 3 дугаар Хавсралтын дагуу ирүүлнэ.

2.7.4 Банкуудаас ирүүлсэн саналыг үндэслэн ТБҮЦ-ны арилжааны хуваарилалтыг хийнэ.

2.8 **Тогтмол хүүтэй бөгөөд хэмжээг хязгаарласан арилжааг** дараахь зарчмаар явуулна:

2.8.1 ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны удирдлагын шийдвэрийг “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан банкуудад 4 дүгээр Хавсралтын дагуу мэдэгдэнэ.

2.8.2 МБСГ нь ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлийг арилжаа хийх өдрийн 9.30 цагт “Банк хоорондын цахим арилжааны систем”-д оруулна.

2.8.3 Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9.30-11.00 цагийн хооронд “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т ирүүлнэ.

2.8.4 Тухайн банкны үнэт цаас худалдан авах санал нь ТБҮЦ-ны зарласан хэмжээнээс хэтрэхгүй байна.

2.8.5 Банкуудын ирүүлсэн нийт санал ТБҮЦ-ны зарласан хэмжээнээс хэтрээгүй бол ТБҮЦ-ны арилжааны хуваарилалтыг банкуудын ирүүлсэн

саналаар хийнэ. Банкуудын ирүүлсэн нийт санал ТБҮЦ-ны зарласан хэмжээнээс их тохиолдолд банк бүрийн саналыг ТБҮЦ-ны зарласан нийт хэмжээг банкуудын ирүүлсэн нийт саналд харьцуулж тооцсон харьцаагаар үржүүлэн үнэт цаасыг хуваарилна.

2.9 ТБҮЦ-ны хүүгээр өрсөлдөх арилжааг зохион байгуулахад дараахь зарчмыг баримтална:

2.9.1 МБСГ арилжаа явагдахаас өмнөх ажлын өдөр “Макро эдийн засаг, банк, санхүүгийн системийн үзүүлэлтүүд” (1А Хавсралт)-ийн байдал, “Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б Хавсралт)-ыг үндэслэн ТБҮЦ гаргах хугацаа, хэмжээний талаархи саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.

2.9.2 ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны Захирлуудын зөвлөлийн шийдвэрийг банкуудад “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан 5 дугаар Хавсралтын дагуу мэдэгдэнэ.

2.9.3 МБСГ нь ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлийг арилжаа явуулах өдрийн 9.30 цагт “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулна.

2.9.4 ТБҮЦ-ыг худалдан авах хэмжээ болон хүүний саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9.30-11.00 цагийн хооронд “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т ирүүлнэ.

2.9.5 Банкуудаас ирүүлэх хүүгийн санал таслалын ард 2 орны нарийвчлалтай жилийн хүү байна.

2.9.6 ТБҮЦ-ыг худалдан авах хүүгийн саналыг банкууд 2 хүртэл хувилбараар ирүүлж болох бөгөөд уг 2 саналын нийлбэр нь тухайн банкны нийт саналын дүнтэй тэнцүү байна.

2.9.7 Монголбанк ТБҮЦ-ыг арилжааны банкуудаас ирүүлсэн хүүгийн саналыг жагсаан хамгийн бага хүүгийн санал өгсөн банкнаас эхэлж энэхүү журмын 7 дугаар Хавсралтын дагуу хуваарилна.

2.10. Банкууд саналаа “Банк хоорондын цахим арилжааны систем”-д нэгэнт оруулсан бол уул саналаасаа татгалзах, түүнийг буцаах, өөрчлөх эрхгүй.

2.11. Хүүгээр өрсөлдөх арилжаанд банкуудаас ирүүлсэн хүүгийн саналыг шударга бус, хуйвалдсан гэж үзвэл Монголбанк ТБҮЦ-ны тухайн арилжааг цуцлах эрхтэй.

2.12 Давагдашгүй хүчин зүйлийн болон цахим арилжааны сүлжээнд эвдрэл гарсны улмаас ТБҮЦ-ны арилжаа 11.00 цагт эхлэх боломжгүй бол Монголбанк арилжаа хийх хугацааг сунгаж болно. Ингэхдээ арилжаа явагдах хугацаа болохоос 10 минутын өмнө банкуудад “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулах эсвэл утсаар мэдэгдэнэ.

- 2.13 МБСГ 12.00 цагт Монголбанкны Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газарт энэ журмын 8 дугаар Хавсралтын дагуу “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр гүйлгээний шийдвэрийг дамжуулснаар гүйлгээ хийгдэнэ.
- 2.14 Хямдруулсан хэлбэрээр банкуудад арилжаалах ТБҮЦ-ны хямдруулсан үнийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
- 2.15 ТБҮЦ-ны хүү болон хямдруулалтын үнийг дараахь томъёогоор тооцно.

$$\text{ТБҮЦ-ны хүү: } d = \left[\frac{F - P}{P} \right] * \frac{360}{t}$$

$$\text{Хямдруулсан үнэ: } P = \frac{F}{1 + d * \left(\frac{t}{360} \right)}$$

d = ТБҮЦ-ны төлөгдөх өдөр хүртэлх t хугацааны хямдруулалтын хүү, жилээр

t = ТБҮЦ-ыг арилжаалсан өдрөөс төлөгдөх өдөр хүртэлх хугацаа

F = ТБҮЦ-ны нэрлэсэн үнэ

P = ТБҮЦ-ны хямдруулсан үнэ

- 2.16. ТБҮЦ-ны нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу бүртгэж, Монголбанкны болон банкуудын тэнцэлд тусгана.

ГУРАВ. ТБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа

- 3.1 Төлөгдөх хугацаа нь болоогүй өөрийн эзэмшилд байгаа ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдах, худалдан авах; репо нөхцлөөр худалдах, худалдан авах хэлцэл хийж болно.
- 3.2 ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа нь “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжина. Монголбанк нь үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр банкуудын хооронд хийгдэх арилжааг зуучлах зорилгоор оролцоно. Монголбанк зуучилсны шимтгэл авахгүй.
- 3.3 Монголбанк төлөгдөх хугацаа нь болсон ТБҮЦ-ны нэрлэсэн үнийг түүний сүүлчийн эзэмшигчид төлнө.
- 3.4 ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдсан болон барьцаалснаас үүсч болох аливаа хариуцлагыг Монголбанк хүлээхгүй.
- 3.5 Монголбанк нь банкуудын хүсэлтээр ТБҮЦ-ны репо санхүүжилт олгож болно. ТБҮЦ-ны репо санхүүжилтийг Монголбанк, арилжааны банкуудын хооронд байгуулсан “Буцаан худалдан авах ерөнхий гэрээ”-гээр зохицуулна.
- 3.6 Банкууд репо санхүүжилтийн саналаа “Банк хоорондын цахим арилжааны систем”-ээр дамжуулан МБСГ-т ирүүлнэ.

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ын
1А хавсралт

**МАКРО ЭДИЙН ЗАСАГ, БАНК, САНХҮҮГИЙН
СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	Үзүүлэлт	Хэмжээ (\pm)
1	Тухайн сарын инфляци: Сарын өөрчлөлт Оны эхнээс өөрчлөлт Жилийн өөрчлөлт	
2	Ханшийн өөрчлөлт : Сарын Оны эхнээс Жилийн	
3	Мөнгөний агрегатуудын өөрчлөлт : Нийт мөнгө: Сарын Оны эхнээс Жилийн Бага мөнгө: Сарын Оны эхнээс Жилийн	
4	Эдийн засгийн өсөлт: Өмнөх оны	
5	Банк хоорондын захын хүү: Өмнөх сарын хүү Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт	
6	Банкуудын хадгаламжийн хүү: Өмнөх сарын хүү Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт	
7	Банкуудын зээлийн хүү: Өмнөх сарын хүү Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт	

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ын
1Б хавсралт

Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал

(+)=Мөнгөн хөрөнгийг нийлүүлэх; (-)=Мөнгөн хөрөнгийг татах	Огноо
А. Нөөцийн нийлүүлэлт (а+б+в+г+д)	
(а) Гадаад цэвэр активт гарах өөрчлөлт	
(б) Засгийн газрын цэвэр зээлд гарах өөрчлөлт	
(в) Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өөрчлөлт	
(г) Бусад нөөцийн өөрчлөлт	
(д) Бусад цэвэр зүйлийн өөрчлөлт	
Б. Банкуудын нөөцийн эрэлт (ж+е)	
(е) Заавал байлгах нөөцийн өөрчлөлт (е)	
(ж) Илүүдэл нөөцийн өөрчлөлт (ж)	
В. Нийлүүлэлтийн илүүдэл (+) эсвэл эрэлтийн илүүдэл (-) (А-Б)	
Г. Монголбанкнаас мөнгөн хөрөнгө нийлүүлэх (+), татах (-) (бодлогын позиц) (з+к+л+м)	
(з) Репо санхүүжилтийн өөрчлөлт	
(к) Овернайт зээлийн өөрчлөлт	
(л) Бусад зээлийн өөрчлөлт	
(м) ТБҮЦ-ны борлуулалтын өөрчлөлт	
Д. Эцсийн позиц (В+Г)	

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
3 дугаар хавсралт

**ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД
ОРОЛЦОХ САНАЛЫН МАЯГТ**

Арилжааны банкны нэр:

Арилжааны дугаар:

Хугацаа: . . . хоног

Гүйлгээ хийх өдөр: . . . оны . . . сарын . . .

Төлөгдөх огноо: . . . оны . . . сарын . . .
.өдөр

Худалдан авах үнэт цаасны хэмжээ: . . . ширхэг

Худалдан авах үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн: . . . сая төгрөг

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
4 дүгээр хавсралт

МЭДЭГДЭЛ

... оны ... сарын ... өдөр

Арилжааны дугаар

Төв банкны үнэт цаасны тогтмол хүүтэй, хэмжээг хязгаарласан арилжааг ...
оны ... сарын ... –ний өдөр явуулах болсныг мэдэгдье.

Арилжаалах үнэт цаасны хэмжээ: ... сая төгрөг

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх огноо: ... оны ... сарын ...

Хямдруулалтын хувь хэмжээ: ... хувь

Нэрлэсэн үнэ: ... төгрөг

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
5 дугаар хавсралт

МЭДЭГДЭЛ

. . . оны . . . сарын . . .

Арилжааны дугаар

Төв банкны үнэт цаасны хүүгээр өрсөлдөх арилжааг оны . . . сарын . . . –ний өдөр хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар явуулах болсныг мэдэгдье.

Арилжаалах үнэт цаасны хэмжээ: . . . ширхэг

Хугацаа: . . . хоног

Гүйлгээ хийх өдөр: . . . оны . . . сарын . . .

Төлөгдөх огноо: . . . оны . . . сарын . . . өдөр

Нэрлэсэн үнэ: төгрөг

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
6 дугаар хавсралт

**ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД
ОРОЛЦОХ САНАЛЫН МАЯГТ**

Арилжааны банкны нэр:

Арилжааны дугаар:

Хугацаа: . . . хоног

Гүйлгээ хийх өдөр: . . . оны . . . сарын . . .

Төлөгдөх хугацаа: . . . оны . . . сарын . . .

	Хямдруулалтын хувь хэмжээ	Ширхэг	Хямдруулсан үнэ	Нэрлэсэн үнэ ₮
1				
2				
Нийт				

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
7 дугаар хавсралт

**ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ
АРИЛЖААНЫ ТООЦООНЫ АРГАЧЛАЛ**

Банкны нэр	Хямдруулалтын хувь	Ирүүлсэн санал (ширхэгээр)	Хуваарилагдсан дүн (ширхэгээр)	Хуваарилалтын коэффициент
(1)	(2)	(3)	(4)	(5)
Нийт дүн				

(1) баганад арилжаанд саналаа өгсөн банкуудыг хамгийн бага хямдруулалтын хувь санал болгосноос нь эхлэн эрэмбэлж бичнэ.

(2) баганад хямдруулалтын хувийг бичнэ.

(3) баганад ирүүлсэн саналын хэмжээг бичнэ.

(4) баганад хуваарилагдсан дүнг бичнэ. Хэрэв банкуудын ирүүлсэн санал гаргасан хэмжээнээс их байвал хамгийн бага хүүгийн хувь санал болгосноос нь эхлэн гаргасан үнэт цаасны хэмжээг дуустал хуваарилна.

Ижил хүүгийн санал өгөөд бүх саналын хэмжээнд хуваарилагдаж хүрэхгүй бол хуваарилагдаагүй үлдсэн үнэт цаасны хэмжээг нийт саналд хуваан тэрхүү хуваарилалтын коэффициентээр ижил хүүгийн санал өгсөн банкуудад хуваарилна.

(5) баганад тухайн саналын хуваарилалтын коэффициентийг бичнэ.

“Төв банкны үнэт цаасны журам”-ын
8 дугаар хавсралт

ГҮЙЛГЭЭНИЙ ШИЙДВЭР

БТМТГ-т

ГҮЙЛГЭЭНИЙ УТГА:

Нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн
нэрлэсэн үнэ бүхий . . . хоногийн хугацаатай
ТБҮЦ-ны . . . тоот арилжааны гүйлгээг дараахь
нөхцлийн дагуу хийх. Үүнд:

	Банкны нэр	Хямдруулалтын хувь хэмжээ (%)	Нэгжийн үнэ	Нэгжийн хямдруулалт	Ширхэг	Худалдах үнэ (₮)	Хямдруулалт	Буцаан худалдан авах үнэ (₮)
1								
2								
...								
	Дүн							

Гүйлгээ хийх өдөр:

Үнэт цаас төлөгдөх өдөр: